

төслийн үзүүлэлт

Төслийн үзүүлэлт - бийнээс залдсан төслийн үзүүлэлт

Төслийн нийтийн шаржийн түүх	Чинжилгээний (зинквирчийн)	Санхүүгийн шаржийн түүх
Оршилоого зарлагын гүйцэтгэлийн	Дагуулж болсон гүйцэтгэлийн	Санхүүгийн шаржийн гүйцэтгэлийн
Гүйцэтгэлийн бусад гүйцэтгэлийн	Гүйцэтгэлийн гүйцэтгэлийн	Санхүүгийн шаржийн бусад гүйцэтгэлийн
Үзүүлэлт Ажлын 2. Тийн шинийн хамгаалалтад шалтгаалалтад шалтгаалалтад	Үзүүлэлт Ажлын 2. Тийн шинийн хамгаалалтад шалтгаалалтад шалтгаалалтад	Үзүүлэлт Ажлын 2. Тийн шинийн хамгаалалтад шалтгаалалтад шалтгаалалтад

## “ABC” ГЭРЭЭТ ТӨСӨЛ: ТАНИЛЦУУЛГА

### Т.Жааваа

Эрхэмсэг ноёд, хатагтай та бүхний энэ өдрийн амгаланг айлгая. Өртгийн системээс хамаарч асар их мөнгө эргэлтээс алдаж, өрсөлдөөн болон хүчний тэнцвэрт нөлөөлж буйг та анзаардаг уу. Тэгвэл “ABC” төслөөр нийлүүлэх нэгэн ашигтай бүтээгдэхүүний багцыг санал болгож, нягт хамтран ажиллахыг урьж байна.

**Үндэслэл:** Төвөөс зугатах хүчиний байнгын үйлчилгээд буй танай байгууллагын эдийн засгийн үнэ цэнэ их урсамтгай биет юм. ABC мэт туйлын мэдрэмтгийн индикатораар дамжуулж өргөн талбайгаар хэмжин барьж авахгүй л бол эргэлтээс үүрд гадагшлаж, бүтээмжийг унагах ба сөрөг (гадагш) урсгалын хүлээлтүүд эсрэг биетэд шилжиж, өрсөлдөгчийн халаасыг зуваатгана.

General Motors, General Electric, аль эсвэл Matsustita, Mitsui одоо хир зах зээлд тэргүүлж буй нууц нь техник, хүмүүн капиталын давуу урсгалд бус ABC зэрэг төгс индикатораар урсамтгай биетийг их талбайтай барьж, гадагш мөнгөн урсгалын хүлээлтүүдийг хаасанд оршдог.

**Танай байгууллагад “ABC” төслийн бүтээгдэхүүн ямар ашиг тусв огог вэ.**

1. Үйлчилгээг дэмжих орц, үйлдлийн холбоос, түүний дизайн хийгээд зардлын урсгалыг салбарын (орон нутаг) удирдлагын менежерүүд илүү дэлгэрэнгүй ойлгоход туслана.

2. ABC шинжилгээнд салбар нэгжийн дотоод дизайн, шугаман үйлдлүүд үнэлэгдэж, жишиг болохуйц оновчтой зураглал ба санхүүгийн дотоод жишиг мэдээллүүд (венчмаркинг) доорх загварын дагуу үүснэ (хүснэгт 1).

3. Салбарын жишигтэй (Benchmarking) сонирхож буй нэгжийг харьцуулж, үнэмлэхүй ялгаатай нөөцийг зөв байршуулах, үйлчилгээний багц, түүний зураг, дизайнныг эргэж хянах, салбар нэгжийг хаах, нэгтгэх, өргөтгөх зэрэг ул үндэстэй хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хувь чавчны тавилдлагад нийтийн бие Гучин-Ус сумын ба  
ХААН банк: хамгийн бага зардал - санхүүгийн венчмаркинг  
А. Нэгж тулхүүр үйлдэл ба гүйлгээ (жишээг хийсвэрлэв)

Гүйлгээ	Дотоод жишиг (венчмаркинг)	Зэрэгцүүлж Буй нэгж
Зээлийн шинжилгээ	100 ₮	150 ₮
Орлого зарлагын гүйлгээ	30 ₮	31 ₮
Гүйвуулга	50 ₮	53 ₮
Бусад гүйлгээ	20 ₮	24 ₮

Б. Нэгж дансны үйлчилгээ: (жишээг хийсвэрлэв)

Үйлчлүүлэгчийн бүлэг	Дотоод жишиг (венчмаркинг)	Зэрэгцүүлж буй нэгж
Жижиг хэрэглэгч	250 ₮	468 ₮
Том (бизнес) нэгж	5300 ₮	6500 ₮

4. Байгууллагын санхүүгийн венчмаркинг мэдээллийг үндэсний банк систем, олон улсын тогтсон жишигтэй өрсөлдүүлэх замаар хүчний тэнцвэр, байршилыг (координат) тэнцвэржүүлэх арга замыг сүвэгчилж, стратегийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргахад туслана.

5. ABC - данс, хадгаламж, зээлийн бүтээгдэхүүний орлого, зардал, ашгийн хэмжлийг нарийвчилж өгнө. Үйлчлүүлэгчийн бүлэг, хадгаламж, зээлийн (бүтээгдэхүүний) багцын тоо хэмжээг эдийн засгийн ашигтай нь уяж өгснөөр зорилтот зах зээл тэлэх маркетингийн үйлдэл болон удирдлагын шийдвэрийг дэмжих мэдээллийн эх сурвалжууд төгсждөг.

6. Данс, хадгаламж, зээлийн багцуудын үйлчилгээг их мэдрэмтгий ашгийн индикатортай уяснаар аль салбар ямар багц түлхүү байрших, хадгаламж, зээлийн хүү хэрхэн буурч, боломжийн бага зардал ба хямд үнээр зорилтот зах зээл эзлэх тухай сэдэж болно.

Өрсөлдөөнт орчинд салбар нэгжүүд аль болох зардлаа хэмнэж, хямд үнийн санал ба үйлчилгээг эрхэмлэх ёстой. ABC шугаман үйлдэл ба ажлын байрын тодорхойлолтыг хөндөх учир илүү орон тоо, үргүй зардлыг арилгахад туслана.

“ABC” төслийн (судалгааны) баг дараах 4 алхмуудыг хэрэгжүүлнэ.

Алхам 1: Салбарын үйлчилгээний дизайн, зардлын багцуудыг үнэлж, тулхүүр үйлдэл, дэмжих орцууд ба түүний (зардлын) хөтлөгчийг тодорхойлно. Судалгааны баг ажлын өдрийн зураг авч, хүмүүстэй ярилцах хийгээд үйлдлийг задлан шинжлэхэд их хүч, цаг зарцуулна. Хэмжилтүүд найдвартай хийгдвл доорх үйлдэл ба зардлын хөтлөгчүүд сонгогдоно.

1-р хүснэгт

Тулхүүр үйлдэл	Зардлын хөтлөгч	Тоо хэмжээ: хийсвэр
Зээлийн өргөдлийн шинжилгээ	Өргөдлийн тоо	200
Орлого зарлагын гүйлгээ	Дансны тоо	415
Гүйвуулга	Гүйлгээний тоо	150, 500
Бусад гүйлгээ	Гүйлгээний тоо	41000

Алхам 2: Үйл явцын урсгал, орц (нөөц) болон тэдний холбоос хамаарлыг зурагласан орц - үйлдэл - бүтээгдэхүүний тарыг бэлтгэж авна. ABC төслийн хамгийн чухал нь нөөцийн хэрэглээ ба тулхүүр үйлдлийн холбоосыг загварчилахад оршдог. Шаардлагатай мэдээллийг ажиглалт, үйлдлийн шинжилгээ, хүмүүстэй ярилцлага хийх замаар олж цуглуулдаг. Үйлдлийн урсгал ба нөөцийн холбоосуудыг олж тогтоосноор судалгааны баг үйл явцын ерөнхий марийг (блок схем) зураглах боломж бүрдэнэ.

Үйл явцын ерөнхий марийг туслах зураглалууд дэмжиж өгнө. Зураглал нь их төвөгтэй ажилбар, өндөр ур чадвар, логик сэтгэлгээ ба загварчлал шаардах ба зөвхөн мэргэшсэн шинжээч нар хийж гүйцэтгэнэ. Шинжээчид үйл явцын урсгалыг бүхэлд нь оношлох, том (бизнес), жижиг хэрэглэгчийн хувьд орц - үйлдэл – бүтээгдэхүүний багцуудыг ялгааг танин мэдэж зураглах үүрэг гүйцэтгэнэ. Ялангуяа том хэрэглэгчийн харилцаа (данс, хадгаламж, зээлийн өргөдөл) их хүч, ажлын цаг, орцууд зарцуулагддаг.

Алхам 3: Орц - үйлдэл - үйлчилгээний зураглалыг ашиглан нөөц болон үйлдэл, зардлын хөтлөгч нэгжүүдийн биет урсгалд холбогдох мэдээллийг цуглуулна. Теллер, эдийн засагч, хүмүүстэй ярилцаж мэдээллийг цуглуулна. Мэдээллийн сурвалжууд санхүүгийн баримт, судалгааны тест болон менежерүүдийн хамгийн сайн таамагт суурилна.

Алхам 4: ABC суурьт өгөгдлийн сан ба мэдээллийн тулхүүр үйлдэл, үйлчлүүлэгч, хадгаламж ба зээлийн багцын хувьд нийт ба нэгж өргтийн дүрсүүдийг тооцно (Хүснэгт 2). Салбар нэгжүүдийн үйлчлүүлэгчийн бүлэг, хадгаламж, зээлийн багцын тоо хэмжээ, орлого, зардал, ашгийн параметрүүдийг үнэлж, улмаар санхүүгийн дотоод венчмаркингүүдиг (жишиг мэдээлэл) гаргаж авахад чиглэнэ.

2-р Хүснэгт

ХААН банк: Тооцооны ... салбар

ABC өртгийн тайлан

Тулхүүр үйлдлийн хөтлөгчүүд			
Үйлдэл	Нийт зардал	Биет урсгал	Нэгж зардал
Зээлийн өргөдөл			
Орлого зарлагын гүйлгээ			
Гүйвуулга			
Бусад гүйлгээ			

Үйлчлүүлэгчийн анги					
	Жижиг хэрэглэгч		Бизнес хэрэглэгч		
	Нэгж зардал	Биет урсгал	Зардал	Биет урсгал	Зардал
Зээлийн оргөдөл					
Орлого зарлагын гүйлгээ					
Гүйвуулга					
Бусад гүйлгээ					
Нийт өртөг					
Дансны тоо					
Нэгж дансны өртөг					

Төслийн баг: гадаад 9, дотоод 2 төслийг амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай. “Монгол тээх”, “Талх чихэр”, “Монгол шевро”, “Монгол шуудан”, “Говь ”, “УБТЗ” зэрэг 20 илгэж, байгууллагад орчин үеийн ортгийн систем туршиж нэвтрүүлсэн.

Үнийн санал: 1.5- 3 сая ₮. 1990 оноос түгж буй хамгийн төгс ортгийн систем. Монголд нэвтрээгүй, танайд анх удаа турших болно. Эхний туршилт, шийдлүүд жигдэрсэнээр үнийн санал 1 сая ₮ хүртэл хямдрах боломжтой.